

https://docs.google.com/document/d/11MsE976669KxEzNfFh25we7LVoc8_DrDIcRQREBzGz4/edit

Дата сэтгүүлзүйн эхлэн сонирхогчдод

Хелена Бенгтсон, Нилс Мулвад

Жижиж төслөөс эхэл.

Дата сэтгүүлзүйд алдаа гаргах олон янзын эрсдэл бий. Тиймээс өөрийнхөө ашиглаж чадах тоон мэдээлэл болон програм хангамжаас эхлэх нь зүйтэй. Шууд томоохон төсөл барьж авсны хэрэггүй.

Сэтгүүлчдэд зориулсан янз бүрийг хэрэгслийг ашиглаж сур

Сэтгүүлч хүний хувьд тооцоолон бодох хэрэгсэл, программын зарчмыг ойлгож авахын танд сэтгүүлзүйн туршлагатай багш хэрэгтэй. Учир нь тодорхой үйлдлүүдийг сэтгүүлзүйн бүтээл, үүрэг даалгавартай холбож бодох шаардлага гарах болно.

Алдаа байгаа эсэхийг ахин дахин нягтал

Их хэмжээний тоон мэдээлэлд бараг үргэлж алдаа байдаг. Тухайн мэдээллийг нэр хүнд бүхий албан байгууллага, эрх мэдэлтнээс авсан ч гэсэн ялгаагүй. Мэдээллийг нийтэд хүргэхээсээ өмнө алдааг олж залруулах нь таны үүрэг хариуцлага юм.

Нийлбэр дүнг үргэлж шалгаж бай. Байх ёстой бүх тоо байгаа эсэх, ямар нэг зүйл дутагдаж байгаа эсэхийг шалга.

Дата мэдээллийн ажлаа баримтжуулж, нийтэд ил болго.

Мэдээллийг бүрдүүлэхийн тулд хийсэн алхам тус бүрээ тоочиж тайлбарла. Ингэснээр бусад хүмүүс таны хийсэн зүйлийг нягталж, давтан хийх боломжтой болно. Ерөнхийдөө тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийсний дараа, нийтлэхийн өмнөх шатанд эх сурвалжид үзүүлж, алдаа байгаа эсэх, мөн тооцоолол хийсэн аргачлал тань зөв эсэхийг шалгаж өгөхийг хүсэх нь буруу биш. Ингэснээр та алдаагүй бүтээл гаргахаас гадна аргачлал болон агуулгатай холбоотой нийтэлсний дараах шүүмжлэлийг багасгана.

Ямар нэгэн алдаа олж тооцоолсон бол түүнийгээ ашиглаж, илүү сайн эх сурвалж олохыг хичээ. Мөн тоон мэдээлэлтэй ажилладаг мэргэжилтэн, эх сурвалж байгууллагатай харилцаа холбоогоо сайжруулахад таны олж мэдсэн зүйл туслах болно.

Тоо баримт олж авах нь

https://docs.google.com/document/d/11MsE976669KxEzNfFh25we7LVoc8_DrDlcRQREBzGz4/edit

Зарим төрлийн мэдээллийг холбогдох мэргэжилтнээс асууж, имэйлээр авах боломжтой. Эсвэл байгууллагын цахим хуудсаас авч, эсвэл Мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулийг ашиглаж хэрэгцээтэй мэдээллээ хүсэмжилж болно. Тийнхүү тоо баримт олж авах аргачлалаа улам бүр хөгжүүлж, сайжруулах хэрэгтэй. Сэтгүүлзүйн судалгааны аргачлалыг сайжруулж болдогтой нэгэн адил.

Тоон мэдээллийг задлан шинжилж, бүтээлийн сэдэв ол

Дата сэтгүүлзүй нь амьд түүхийг өгүүлэх ёстой. Хэтэрхий их тоо баримтын дунд сэтгүүлзүй гэх юмгүй бүтээл цөөнгүй гардаг. Тоон дотроос амьд түүх харагдахгүй бол нийтлэхээс түдгэлз. Интерактив график ашиглахад ч ялгаагүй. График, зураглалыг тодорхой асуудал хөндөх, ямар нэг зүйлийг хэлэх зорилготой хэд хэдэн хэсэгт хувааж бүлэглэ. Урт сунжирсан, олон өнцөг бүхий хүснэгт, график дотор байгаа бүх мэдээллээ хольж хутгахаас зайлсхий.

Туйлын нөхцөл байдлыг харьцуулж үз

Тоо баримтан дундаас бодит түүхийг олж босгохын тулд ахин дахин бод. Бусдад ярьж өгөх гэсэн тэрхүү түүхээ бодит байдалтай харьцуулж үг. Уншууртай, сонирхолтой түүхийг өгүүлэхийг тулд байгаа байдлыг туйлын нөхцөл байдалтай (байж болох хамгийн сайн, хамгийн муу зүйлтэй) харьцуулах нь дөхөмтэй байдаг. Жиших, харьцуулах, эрэмбэлэх зэргээр бодит байдлыг тайлбарлаж болно. Энэ бол сэтгүүлзүй.

Дата сэтгүүлзүй зарим тохиолдолд болсон явдлаас эхэлдэг. Зарим үед тоо баримтаас эхэлнэ.

Ямар нэг болсон явдал, хэн нэгний түүхээс эхэлж, тоо баримтаа эргэн тойронд нь шигтгэх хэрэгтэй гэж боддог сэтгүүлч олон бий. Дата сэтгүүлзүйн бүтээлийг заавал ингэж хийх албагүй. Зарим үед тоо баримтын цуглуулга маань өөрөө асуудлыг дэвшүүлээд өгдөг. Бусад тохиолдолд баримтыг нэлээд гүнзгий судалж байж, цаана нь юу байгааг олж харах, мөн нягтлан шалгах хэрэгтэй болдог.

Тоо баримтыг шалгаж, цэвэрлэх ажлыг өөрөө гүйцэтгэ.

Баримт мэдээлэл байхгүй үед өөрийн гэсэн мэдээллийн бааз үүсгэх нь гайхалтай бүтээл бэлтгэх таны өөрийн арга замыг засч өгдөг. Тоог өөрөө бодож тооцоолсноор агуулгыг мэдэрч, дэвшүүлж болох асуудал, алдаа мэдгийг олж авах нь илүү хялбар болдог. Тиймээс тоо бодох ажлыг судлаачдад бүү үлдээ, өөрөө л хий. Тоонд дурла.

Тооноос сал

Дата сэтгүүлзүйн нь ихэвчлэн хүний тухай байдаг. Бичвэр бэлтгэхдээ тооноос салж, харин тэдгээр тоог бодитоор харуулах амьд хүнийг ол. Яг үнэндээ зарим үед огт тоогүйгээр

https://docs.google.com/document/d/11MsE976669KxEzNfFh25we7LVoc8_DrDlcRQREBzGz4/edit

датаСЭТГҮҮЛЗҮЙН бүтээл гаргах нь хамгийн сайн арга байдаг. Амьд түүхийг харуулангаа тоо, баримтаа графикаар харуулж болно. Таны тоог баталгаажуулах амьд жишээ олдохгүй бол баримт тань худлаа байж болох юм.

Хамтран ажиллаж, бусадтай хуваалц

Дата сэтгүүлзүйн хүрээнд олсон, хийснээ бусадтай хуваалцдаг сайхан уламжлал бий. Зөвхөн ингэж л бид мэдээллийн технологи, мэдээллийг боловсруулах төрөл бүрийн хэрэгслийн хөгжлийг хоцролгүй дагаж чадна. Тийм ч учраас дата сэтгүүлзүйн салбарт бусадтай хуваалцах, хамтарч ажиллах нь сэтгүүлзүйн бусад төрөл чиглэлээс илүү хүчтэй хөгжсөн байдаг.

Excel –ийг бүү март

Тоо баримтыг програмд хөрвүүлж, цэвэрлэж, ангилж, задлан шинжилж, буцаан хөрвүүлэх гол хэрэгсэл бол Excel юм. Тиймээс Excel-д суралцаж, байнга ашиглахыг зөвлөж байна. Шинээр гарч ирж байгаа олон сайхан програм, аппликэйшн бий. Гэхдээ тэдгээр нь бүгдээрээ танд хэрэгтэй гэж эндүүрч, хамгийн суурь хэрэгсэл болох Excel-ийг мартаж алдаа гаргав. Гялгар цалгар, сайхан харагддаг олон аппликэйшн хамгийн үндсэн тооцооллыг буруу хийдгийг бид мэднэ.

Тоон мэдээллийн эх хувийг олж ав

Байгууллага, судлаачдаас тоон мэдээлэл хүсэхдээ маш тодорхой байх хэрэгтэй. Сэтгүүлчдийн хувьд бидэнд ангилж, харьцуулж, нэмж, хассан буюу боловсруулсан бус, “түүхийгээрээ” байгаа тоо хэрэгтэй. Тэдгээр тоог бид стандарт хэлбэрээр буюу xml, json, csv, гэх зэрэг форматаар нь авах хэрэгтэй. Мөн тэдгээр тоог хот, дүүрэг, аймаг сумд зэргээр нь харьцуулах боломжтойгоор авах хэрэгтэй. Тоон мэдээллийн ангилал нь товч, тодорхой байх ёстой. Албан тушаалтнууд тоон мэдээллийг танилцуулах биш, бид өөрсдөө үүнийг хийх ёстой.

Хүчтэй талаа хөгжүүлж, багаар ажилла.

Салбар бүрийн хөгжлийг та гүйцэхгүй. Тиймээс өөрийнхөө хүчтэй тал дээр гол анхаарлаа хандуулж, багийн ажилд хувь нэмрээ оруул.

Танд энэхүү жагсаалтад нэмж оруулах заавар, зөвлөмж байвал nils.mulvad@kaasogmulvad.dk –д имэйл бичээрэй.